

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес редакции: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес издателя: 191186,
Санкт-Петербург, д. 18.
Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

Издание осуществлено
при финансовой поддержке
РНФ и Кабинета Министров
Республики Татарстан в рамках
научного проекта № 23-28-10046
и в соответствии с Программой
стратегического академического
лидерства Казанского
(Приволжского) федерального
университета.

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/rnpt-9kut-xa91

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXVII • 2024 • № 1

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Посвящается 70-летию юбилею российских
монголоведов Л. С. Дампиловой и Ю. В. Кузьмина

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,*
доктор филологических наук (Россия)
Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат*
филологических наук (Россия)
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН*
(Россия)
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук*
(Монголия)
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Ц. Саранцацрал, *доктор филологических наук*
(Монголия)
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор*
(Россия)
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 11.03.2024

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Адрес типографии: 191040. Санкт-Петербург. Пушкинская ул., 4.

e-mail: editor@isvov.ru

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2024

© Коллектив авторов, 2024

В НОМЕРЕ:

- Л. С. Дампилова — исследователь литературы и шаманских песнопений монгольских народов (к 70-летию) (От Редколлегии) 5
Ю. В. Кузьмин — иркутский историк-монголовед (к 70-летию) (От Редколлегии) 9

ФИЛОЛОГИЯ

- Сэржээгийн Мөнхсайхан.** Дундад үеийн монгол хэлний а, е эгшгийн авианы онцлог (Особенности фонем гласных “а” и “э” средневекового монгольского языка) 13
Ю. А. Иоаннесян. Из истории изучения и классификации персидских и других западно-иранских диалектов 18
Эцзиньцайжан (Огьен Церинг). Четырехязычное издание «Сутры в сорока двух разделах» 25
В. Ю. Климов. Стихотворные славословия Синрана, посвященные Дао-чо (562–645) 30
Р. П. Сумба. Рукописи и ксилографы на тибетском языке из фондов Национального музея Республики Тыва 42

ИСТОРИЯ

- Агваанцэрэн Мандирмаа.** Годы жизни А. М. Позднеева во Владивостоке (1899–1903) 48
Ю. В. Болтач. Упоминания Тибета (Тхобон) и отражение первых прямых тибетско-корейских контактов в разделе «Наследственные дома» «Истории Корё» (Корё са) 57

НАУЧНАЯ ЖИЗНЬ

- Дандарын Ёндон (1944–1996) (От Редколлегии) 68
Осорнамжимын Сухэбатор (1944–2005) (От Редколлегии) 70
К. А. Бекетов, Н. К. Бекетова, Хурэлбатор Дамдинсурэн. «Дорогами Н. К. Рериха»: экспедиция Санкт-Петербургской академии художеств имени Ильи Репина в Монголию (начало) 71
С. Л. Бурмистров. Первая ежегодная международная конференция памяти Всеволода Семенцова «Философские тексты на санскрите: проблемы чтения и интерпретации» (Джайпур, 22–28 ноября 2022 г.) 89
Ю. В. Болтач, И. В. Кульганек. XII Санкт-Петербургские тибетологические чтения, посвящённые 145-летию со дня рождения Б. Б. Барадийна (1878–1937) (14 ноября 2023 г., ИВР РАН) 93

РЕЦЕНЗИИ

- Т. Д. Скрынникова.** Новые книги по монголоведению 98
Т. Г. Басангова. Труды по калмыцкой фольклористике за 2023 год 103

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)

MONGOLICA



Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXVII • 2024 • No. 1

The journal is published four times a year.

Published since 1986

Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

**Dedicated to the 70th anniversary of the Russian
Mongolists L. S. Dampilova and Yu. V. Kuzmin**

191186, Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18
Phone: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Editorial board:

I. V. Kulganek — *editor-in-chief, D. Sc. (Philology),
Russian Federation*

D. A. Nosov — *secretary, Cand. Sc. (Philology),
Russian Federation*

M. A. Kozintcev — *assistant secretary, Russian
Federation*

G. Bilguudei. *D. Sc. (Philology), Mongolia*

A. Birtalan. *Ph. D., Hungary*

S. Chuluun. *Academician of the Mongolian Academy
of Sciences, Mongolia*

L. S. Dampilova. *D. Sc. (Philology), Russian Federation*

J. Legrand. *D. Sc., Professor, France*

V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*

E. E. Khabunova. *D. Sc. (Philology), Russian Federation*

N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*

E. Munkhtsetseg. *Cand.Sc. (Philology), Mongolia*

S. L. Neveleva. *D. Sc. (Philology), Russian Federation*

K. V. Orlova. *D. Sc. (History), Russian Federation*

M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*

R. Pop. *Ph. D., Romania*

Ts. Sarantsatsral. *D. Sc. (Philology) Mongolia*

T. D. Skrynnikova. *D. Sc. (History), Russian Federation*

R. M. Valeev. *D. Sc. (History), Russian Federation*

N. S. Yakhontova. *Cand. Sc. (Philology), Russian
Federation*

I. V. Zaytsev. *D. Sc. (History), Professor of the Russian
Academy of Sciences, Russian Federation*

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/rmpt-9kut-xa91

© Institute of Oriental Manuscripts RAS

(Asiatic Museum), 2024

© Group of authors, 2024

IN THIS ISSUE:

- L.S. Dampilova — Researcher of Literature and Shamanic Chants of the Mongolian Peoples
(on the 70th Anniversary of the Scholar) (By Editorial Board) 5
- Yuri V. Kuzmin — Historian and Mongolist from Irkutsk (on the 70th Anniversary of the Scholar)
(By Editorial Board) 9

PHILOLOGY

- Serjee Munkhsaikhan.** Features of the Phonemes of Vowels “a” and “e” of Medieval Mongolian 13
- Youli A. Ioannesyan.** From the History of the Study and Classification of Persian
and Other West Iranian Dialects 18
- Ejincairang (Ogyen Tsering).** About the Quadrilingual Edition of the “Sutra in Forty-two sections” 25
- Vadim Yu. Klimov.** Poetic Praises of Shinran dedicated to Dao-cho (562–645) 30
- Rita P. Sumba.** Tibetan manuscripts and Block prints from the collections
of the National Museum of the Republic of Tuva 42

HISTORY

- Agvaantseren Mandirmaa.** Years of Life of A. M. Pozdnev in Vladivostok (1899–1903) 48
- Julia V. Boltach.** Mentions of Tibet (Tobea) and the Reflection of the Early Contacts between
Tibetans and Koreans in the Hereditary Houses Section of the History of Goryeo (Goryeo sa) 57

ACADEMIC LIFE

- Dandaryn Yondon (1944–1996) (By Editorial Board) 68
- Osornamzhsimyn Sukhbaatar (1944–2005) (By Editorial Board) 70
- Konstantin A. Beketov, Natalya K. Beketova, Khurelbaatar Damdinsuren.**
“The Roads of N. K. Roerich”: the Expedition of St. Petersburg Ilya Repin Academy of Arts
to Mongolia (Beginning) 71
- Sergei L. Burmistrov.** First Annual International Conference in Memory
of Vsevolod Sementsov «Philosophical Sanskrit Texts: Problems of Reading and Interpretation»
(Jaipur, November 22–28, 2022) 89
- Julia V. Boltach, Irina V. Kulganek.** The Twelfth St. Petersburg Seminar
of Tibetan Studies dedicated to 145th anniversary of B. B. Baradiin (1878–1937)
(St. Petersburg, November 14, 2023, IOM RAS) 93

REVIEWS

- Tatiana D. Skrynnikova.** New Books on Mongolian Studies 98
- Tamara G. Basangova.** Proceedings and Publications on Kalmyk Folklore in 2023 103

СЭРЖЭЭГИЙН МӨНХСАЙХАН
ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ “А”, “Е” ЭГШГИЙН АВИАНЫ ОНЦЛОГ

Бидэнд уламжлан ирсэн бичгийн дурсгалууд нь монгол хэлний өнгөрсөн түүхийг судлах чухал баримт хэрэглэгдэхүүн болдог. Ялангуяа хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалууд нь тухайн цагийнхаа амьд ярианы хэлний байдлыг тэмдэглэсэн тул дундад үеийн монгол хэлний авиа зүй, үг зүй, үгийн сан зэрэг хэл шинжлэлийн олон талын судалгаа хийхэд нэн тохиромжтой юм. Тус өгүүлэлд уйгуржин монгол бичиг болон дөрвөлжин бичигт тэмдэглэгдсэн а, е эгшгүүдийн үсэг зүйн онцлог нь тухайн эгшгүүдийн авианы шинжид тулгуурласан болохыг баримт түшин өгүүлжээ. Судалгааны дүнд дундад үеийн монгол хэлэнд дуудлагын зөрүүтэй хоёр е эгшиг байсан гэж үзсэн бөгөөд учир нь хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалуудад тэдгээрийг тодорхой ялган бичсэн олон тооны жишээ байдаг ажээ.

Түлхүүр үг: уйгуржин монгол бичиг, дөрвөлжин бичиг, хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалууд, а эгшиг, е эгшиг.

Сэржээгийн Мөнхсайхан: Хэл бичгийн ухааны доктор, дэд профессор, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан; ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн (Улаанбаатар хот, Монгол улс) (munkhsaikhans@mas.ac.mn).

© ИВР РАН, 2024

© Сэржээгийн Мөнхсайхан, 2024

Орчин цагт уламжлан ирсэн уйгуржин, дөрвөлжин, хятад, араб үсгийн дурсгалуудад дундад үеийн монгол хэлний байдлыг тодорхой тэмдэглэн үлдээжээ. Үүнээс хятад, араб үсгийн дурсгалууд нь ярианы хэлний галиг байдгаараа онцлогтой. Тухайлбал, хятад үсгийн дурсгалуудад ярианы хэлэнд авианы харилцан нөлөөллийн үр дүнг тусгасан олон сонирхолтой баримт¹ байдаг. Энэ удаад зөвхөн а, е эгшгийн авианы онцлогийг тусгайлан судалж үзэв. Юуны өмнө а, е эгшгийг бичигт хэрхэн тэмдэглэсэн үсэг зүйн онцлогийг тодруулбал:

уйгуржин монгол бичигт: а нь титэм+шүд, е нь

титэм; титэм+шүд

дөрвөлжин бичигт: а нь титэм

е нь титэм+үндсэн үсгээс бүтэх боловч хоёр өөр дүрсээр тэмдэглэжээ. Тодруулбал, уул хоёр бичиг нь хоёул дээрээс доош бичдэг, үсэг бүр үгийн эхэн, дунд, адагт орох өөр өөр дүрстэй.

Мөн хоёр бичигт хоёуланд нь үгийн эхэнд ордог эгшиг үсгүүд титэмтэй байдаг ажээ.

Уйгуржин монгол бичигт а эгшгийг үгийн эхэнд титэм+шүд гэж, үгийн дунд, адагт е эгшигтэй адил дүрсээр тэмдэглэдэг. е эгшгийг үгийн эхэнд олонхдоо дан титмээр тэмдэглэдэг боловч титэм+шүд гэж тэмдэглэсэн хэлбэр ч бас тохиолдоно. Үгийн дунд шүд, үгийн адагт сүүлээр тэмдэглэдэг.

Дөрвөлжин бичигт а эгшгийг үгийн эхэнд дан титмээр, үгийн дунд, адагт тусгай дүрсээр ялган тэмдэглэдэггүй, төвөд бичгийн уламжлалын адил зөвхөн байрлалаараа илэрнэ. Өөрөөр хэлбэл, а эгшгээр амилдаг гийгүүлэгчээр дамжин далд байдлаар илэрдэг. е эгшгийн тухайд, үгийн эхэнд титэм+үндсэн эгшгийн дүрсээс бүтнэ. Үүнийг үсэг зүйн талаас титэм нь үгийн эхний байрыг заасан, үндсэн дүрс нь е эгшгийг тэмдэглэсэн, уйгуржин монгол бичгийн эртний дурсгалуудад үүнтэй адилаар титэм+шүд тэмдэглэсэн байдаг гэж үзэх нь бий. Өөрөөр

¹ Тухайлбал авиа сулрах, авиа сугарах, авиа ижилсэх, авиа давхарлах, авиа сэлгэх гэх мэт.

хэлбэл, уйгуржин монгол бичгийн үсэг зүй анх бүрэлдэн тогтох үед үгийн эхний е эгшгийг титэм+шүд гэж тэмдэглэдэг байсны гэрч нь монгол хэлний дундад үеийн бичгийн дурсгалуудад үлдсэн ба хожим Пагба лам төвөд үсгийн дүрс дээр тулгуурлан дөрвөлжин үсгийг зохиохдоо монгол бичгийн уул тогтолцоог үндэс болгосон [Төмөртоогоо, 2023. Х. 32–35] гэж үздэг. Иймээс дөрвөлжин бичгийн нэг онцлог бол хоёр өөр дүрс бүхий е эгшгийг тэмдэглэсэн явдал юм. Тухайлбал, е эгшгийн хоёр дахь хувилбар буюу урагшилсан è-ийг титэм+үндсэн үсгийн дүрсээр тэмдэглэсэн байдаг. Мөн тус хоёр е эгшгийн ялгааг дундад үеийн монгол хэлний авиалбар зүйн шинжийн талаас авч үзсэн² тайлбарууд ч бас байдаг. Тухайлбал, Өвөр Монголын эрдэмтэн Зууннаст дурдсан (урагшилсан) è-ийг тусгайлан судалж, дөрвөлжин үсгийн 23 дурсгал дахь нийт 584 тохиолдлыг бүртгэн гаргаж, дөрвөлжин бичиг дэх уг үсэг нь угтаа i авиаг тэмдэглэсэн [Зууннаст, 1990. Х. 23–29] гэж үзсэн байдаг.

Тэгвэл бичигт ялгаатай тэмдэглэсэн дээрх а, е эгшиг нь ярианы хэлэнд чухам ямар онцлогтой байсныг ижил цаг үед хамаарах хятад үсгийн дурсгалуудаас тодруулан үзье. Өөрөөр хэлбэл, хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалууд³ нь тухайн цагийн амьд ярианы хэлний байдлыг тэмдэглэсэн байдаг тул а, е эгшгийн авиа зүйн шинжийг тодруулахад хэл шинжлэлийн үндэстэй, бодит баримт болно. Юуны өмнө 1264 онд зохиогдсон Монгол и юй тольд:

А эгшиг:

- Үгийн эхний а эгшгийг тодорхой ялган бичдэг. Жишээ нь,
abuqa (阿不合) “авга”
aqa (阿合) “ах”

² Ө. Хөгжилт “Дөрвөлжин үсгийн е ба è-ийн тухай” — Монгол хэл шинжилгээний өгүүллүүд, 1987. Х. 943–956, Shiro Hattori “The hP’ags-pa letter and è represent one and the same Mongolian vowel”, -Gedanke und wirkung, Festschrift zum 90, Wiesbaden, 1989. P. 46–151, 照那斯图, 有关八思巴字母è的几个问题. 八思巴字和蒙古语文献 I 研究文集, Institute for the study of language & Cultures of Asia & Africa, Tokyo University of foreign studies 1990. P. 23–29.

³ Үүнд, Монгол и юй толь 蒙古譯語 /1264/, Монголын нууц товчоо 元朝秘史 /XIV зууны II хагас/, Хуа и и юй толь 華夷譯語 /1389/, Бэй лу и юй 北虜譯語 /1598/, Лу лун сай люэ-ийн орчуулга үг 盧龍塞畧 /1610/, Бэй лу као 北虜考 /1621/ зэргийг дурдаж болно.

- Хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалуудад монгол үгийг авиачлан галиглахдаа хоёр хэлний адил талыг түшиглэсэн буюу монгол хэлний үгийн үеийг хятад хэлний дуудлага ижил үе үг (ханз үсэг)-ээр тэмдэглэсэн байдаг. Ингэж тэмдэглэхэд задгай, тэргүүн үеийн а эгшиг арын үи-ийн нөлөөгөөр тагнайшсаныг 愛 буюу ai-гаар тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, энэ нь а эгшгийн тагнайшсан хувилбар болно. Жишээ нь, ауеуа<ау+уе+а (愛联合) “аяга”
наууан<нау+уа+n (乃彦) “наян” гэх мэт.
- Мөн үгийн дунд орсон а-г ai-аар тэмдэглэсэн байдаг. Жишээ нь, jiqaisu (只海速) “загас”.

Е эгшиг: Үгийн эхэнд орсон е эгшгийг гурван янзаар тэмдэглэжээ. Үүнд,

- 厄(e) ханзаар уйтан е эгшгийг тэмдэглэсэн боловч тун цөөн тохиолддог. Жишээ нь, ebugan /ebügen/ (厄不干) “өвгөн”,
- 阿(a) ханзаар нэлээн агуу хэлэгддэг е эгшгийг тэмдэглэжээ. Жишээ нь, akö /eke/ (阿可) “эх”,
ale /ere/ (阿列) “эр”
ame (阿滅) “эм”
aköci /ekeci/ (阿可赤) “эгч”
amugan /emügen/ (阿母干) “эмгэн”
amudu /emüdü/ (阿母都) “өмд”
anda /ende/ (按答) “энд” гэх мэт.
- Мөн үгийн эхний е-ийг 愛(ai)-гаар бас тэмдэглэжээ. Жишээ нь, aičige /ečige/ (爱赤哥) “эцэг”
aibin /ebin/ (爱賓) “эбин-их авга”
aimian /emen/ (爱免) “бэр”
aibasun /ebesün/ (爱佰孫) “өвс” гэх мэт.

Тэгвэл Монголын нууц товчоонд уул хоёр эгшгийг хэрхэн тэмдэглэснийг үзвэл үгийн эхэн, дунд, адагт хаа орсноос үл хамааран ямагт 阿(a) ханзаар тэмдэглэснээс гадна үгийн өргөлтөт үе, өргөлтгүй задгай, битүү үеийн алинд ч ийнхүү тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, а эгшиг нь үгийн хаа тохиолдохоос үл хамааран тод хэлэгддэг байсан ажээ. Жишээ нь, aba 阿把, abalaasu 阿巴刺阿速 гэх мэт. Үеийн эхэнд ai, am, an, ang, au гэж тэмдэглэж, Монголын нууц товчоонд гарах бүх гийгүүлэгч авиатай нийлж битүү, задгай үе үүсгэсэн байхын сацуу өөрийн хэлэгдэх байдлаа тогтвортой хадгалж байна. Үүнийг хүснэгтлэн үзүүлбэл:

Д/д	Латин галиг	Монгол хэлний үеийг тэмдэглэсэн хятад ханз үсэг			Жишээ
		Үгийн эхэнд	Үгийн дунд	Үгийн адагт	
1.	a	阿	阿	阿	阿刺阿速 (ala'asu)
2.	ai	唉, 埃		埃	唉亦 (ayui)-аялга үг
3.	am	俺, 奄			奄都 ^舌 里 ^鼻 苔 ^舌 侖 (amduriqdarun)
4.	an	安		安	安達 (anda)
5.	ang	昂			昂 ^中 合 (angqa)
6.	au	奧			奧 ^中 合 (auqa)

Тэгвэл е эгшгийн хувьд уг эгшиг дангаар үе бүтээсэн тохиолдолд үгийн эхэнд 厄, 額 гэж, үгийн адагт 額 гэж тус тус тэмдэглэсэн байдаг бол гийгүүлэгч авиатай нийлж хэрхэн үе (задгай, битүү) бүтээснийг үзвэл:

Задгай үед: be 別, bei 北, 伯; de 迭, 經, 跌, 啞, 埵, dei 德, 歹;

ge 格, gei 該; he 赫, 協, hē 協; je 者, 折, 哲, jei 澤, 者;

ke 客, 格, kei 克; le 列, 洌, 烈, 連, 舌列, lē 列;

me 篋, 馬; ne, n-e 捏, 涅, 年; re 舌列, 舌洌, se, s-e 泄, 洩, 薛;

te 帖, 驛, tei 台;

Битүү үед: ben 邊, beng 邦; dem 點, den 顛, deng 登;

gem 兼, gen 堅, 干; hem 含; jem 詹, 帖, jen 瓊, 瞻;

kem 坎, 砍, 弁, ken 虔, 刊, 牽, 虔; len 連, 漣, leng 涼, 良, 郎;

men 綿; nem 粘, nen 年, 撚, neng 能; rem 舌廉,

ren 舌漣, 舌連, 舌漣, 舌憐, 舌連; sen 三, 先,

seng 襄, 乘, 桑, 想, 僧, 相; tem 忝, 添, ten 田, 壇, teng 騰;

Нийлмэл эгишг: geü- 苟, 鉤; jeü 趙, jeu (jēw) 沼; new 耨 гэх мэт байна.

Дээрх тэмдэглэгээнээс үзвэл дараах зүй тогтол ажиглагдаж байна.

Задгай үед: a/ be, de, le, me, ne, re, se, te-д (別, 迭, 篋, 列, 洌, 烈, 捏, 涅, 泄, 洩, 帖) орсон е эгшгийг ie нийлмэл эгшгээр,

b/ ge, je, ke-д (格, 客, 者, 折, 哲) орсон е эгшгийг дан е (уйтан) эгшгээр

v/ he-ийг (赫, 協) ie, e-ийн аль алинаар тус тус тэмдэглэжээ.

Битүү үед: a/ ben, dem, den, gem, gen, len, men, nem, nen, ren, rem, sem, sen, tem, ten (邊,

點, 顛, 兼, 堅, 連, 漣, 綿, 年, 撚, 舌廉, 先, 忝, 添, 田) үеүдэд орсон е эгшгийг ie/ia нийлмэл эгшгээр тэмдэглэсэн

b/ η-ээр төгссөн битүү үе (deng, leng, neng, seng, teng)-д e-ээр (уйтан) тэмдэглэсэн байна. [Мөнхсайхан, 2021. X. 102–103] Өөрөөр хэлбэл, эдгээр тэмдэглэгээнээс үзвэл дундад үеийн монгол хэлэнд ялгаатай дуудагддаг хоёр е эгшиг байсан, тодруулбал хэлний урдуур хэлэгддэг d, t, s, l, n, r болон уруулын b, m гийгүүлэгчийн араас орсон е эгшиг нь агуу, g, j, k зэрэг гийгүүлэгчийн араас орсон е эгшиг нь нэлээн уйтан байдалтай хэлэгддэг байсан бололтой. Ерөөс монгол хэлний g, k гийгүүлэгч нь зөвхөн хэлний урдуурх e, i, ö, ü эгшигтэй үгэнд тохиолддог онцлогтой билээ. Түүнчлэн тэргүүн үеийн е эгшгийг мөн хоёр өөр ханзаар тэмдэглэсэн нь дуудлага ялгаатай байсныг тэмдэглэсэн байж болно. Учир нь, Монголын нууц товчоонд үгийн утга ялгах үүднээс бичлэг ялгаатай ханз ашигладаг, хэл зүйн бүтэвэрүүдийг тусгай ханзаар ялган тэмдэглэдэг, эр эм эгшгийг дуудлага ижил боловч өөр бичлэгтэй ханзаар ялган тэмдэглэдэг гэх мэтээр монгол хэлний онцлогийг тусгасан жишээ олон байдаг. Тиймээс е эгшгийг ийнхүү ялгаж тэмдэглэсэн нь тухайн үеийн ярианы хэлэн дэх авиа зүйн онцлогийг тусгасан байж болох⁴ талтай. Жишээ нь,

e[b]de'esü 厄 ₁ 迭 ₁ 額 ₁ 速	“өвдөөс”
ebde'et 額 ₁ 迭 ₁ 額 _揚	“өвдөөс”
ebdegü 厄 ₁ 迭 ₁ 古	“өвдөх”
ebdejü 額 ₁ 迭 ₁ 周	“өвдөх”
ebden 額 ₁ 顛	“өвдөн”

⁴ Нэг үгийг дуудлага ижил, бичлэг өөр ханзаар тэмдэглэсэн учир утгын ялгааг тэмдэглээгүй харин тухайн цагт өгүүлэхийн явцад ажиглагдаж байсан авианы ялгаатай шинжийг тэмдэглэсэн байх илүү магадлалтай.

ebdetkün 厄迭坤	“өвдөгтүн”
ebedüksen 額別都先	“өвдсөн”
ebedümü 額別都木	“өвдмү”
ebetčin 厄別臣	“өвчин”

гэж тус тус галигласан байдаг.

Түүнчлэн Лу лун сай люэ (盧龍塞畧)-ийн 19, 20-р бүлгийн орчуулгын бүлэг (譯部) /1610 он/-т е эгшгийн хэд хэдэн тэмдэглэгээ байдаг. Үүнд:

1. 額 ханзаар буюу е эгшгээр тэмдэглэсэн, үүнд:

emüne 額末捏	“өмнө”
eüden 偶丹	“үүд”
eličen 額里臣	“элчин”
elinčük 額林觸克	“элэңцэг”
eneriküi 額捏里恢	“энэрэх”
2. 我 ханзаар буюу ө-өөр тэмдэглэсэн, үүнд:

ögin (+sala) 我近 /撒喇/	“эхэн сар”
	/тэргүүн сар/
öjige öke 我只个我克	“эцэг эх”
ömagik 我麻吉克	“эмэг эх”
öbügen 我卜干	“өвгөн”
3. 阿 ханзаар тэмдэглэсэн, үүнд:

aröne 阿羅捏	“өрнө”
angke 昂客	“энх”

гэх мэт жишээ байна. Дурдсан жишээнээс үзэхэд хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалуудад ялгаатай е эгшгийг тэмдэглэсэн болохыг мэдэж болно. Үүнд, 額/厄 ханзаар бичгийн хэлний е эгшгийг, харин 我 болон 阿 ханзаар тэрхүү бичигт тэмдэглэгдсэн е эгшгийн ярианы хэлэн дэх авианы ялгааг тус тус тэмдэглэжээ.

Түүнчлэн дундад үеийн монгол хэлний а, е авиатай холбоотой түүхэн хэл зүйн баримтаас үзвэл а, е эгшиг нь ихэвчлэн тэргүүн үеийн уруулын эгшигт татагдан ижилссэн тохиолдол олон байна. Жишээ нь:

о-гийн дараа орсон а: Дундад үеийн монгол хэлэнд үгийн тэргүүн бус үед орсон а нь тэргүүн үеийнхээ уруулын о эгшигт татагдан дэвшин ижилсэх үзэгдэл байсан бөгөөд “Монголын нууц товчоо”-нд ч энэ үзэгдэл тэмдэглэгджээ. Жишээ нь,

boqtalaju 孛塔剌周 > boqtolaju 孛脫剌周
“богтолж”

oqatur 鞞合秃兒 > oqodur 鞞豁都兒
“огтор”

to'a 脫阿 > to'o 脫鞞	“тоо”
tonaq 脫納 > tonog 脫那	“тоног”
joban 勺般 > j oboju 勺孛周	“зов-”
orqa 鞞兒合 > orqo 鞞兒豁	“иргэн оргон”

qotat 中豁塔 > qotot 中豁脫
“хотод”

mona 抹納 > monog 抹那 “мөнөө”

ü/ö-ийн дараа орсон е: Тэргүүн бус үед орсон е эгшиг нь тэргүүн үеийн ö эгшигт татагдан дэвшин ижилссэн жишээ байна.

hörene 訶列捏 > höröne 訶羅捏
“өрнө”

örmege 鞞兒篋格 > örmüge-ben 鞞兒木格邊
“өрмөг”

köser-e 闊薛列 > kösör-tür 闊雪兒途兒
“хөсөр”

öter 鞞帖兒 > ötör 鞞脫兒 “үтэр”

öre 鞞列 > örö 鞞羅 “өр”

türgen-e 秃兒格捏 > түргүн-e 秃兒古捏
“түргэнээ”

törelüksen 脫列都先 > töröldüksen 脫羅勒都先
“төрөлдсөн”

köndeledüy ^ü 欸迭列都由 > köndöledü-de 欸多列都迭
“хөндөлд-”

önecid-ün 鞞捏赤敦 > önöcid-ün 鞞那赤敦
“өнчдийн”

гэх мэт жишээ байна.

ДҮГНЭЛТ. Хятад үсгээр тэмдэглэгдсэн монгол хэлний дурсгалууд нь дундад үеийн монгол хэлний тухай олон баримтыг хадгалж байдаг ба тэдгээрийг шинжлэн үзсэний дүнд уйгуржин монгол бичиг болон дөрвөлжин бичигт тэмдэглэгдсэн а, е эгшгүүдийн үсэг зүйн онцлог нь тухайн эгшгүүдийн амьд ярианы хэлэнд байсан авианы шинжид тулгуурласан хэмээн дүгнэж байна. Тухайлбал, дөрвөлжин бичигт тэмдэглэгдсэн хоёр өөр дүрс бүхий е эгшиг, мөн уйгуржин бичигт тохиолдож буй титэм+шүд гэсэн е эгшгийн тэмдэглэгээ нь угтаа ярианы хэлэнд байсан дуудлагын хувьд нэлээн зөрүүтэй (нэг нь агуу, нөгөө нь нэлээн уйтан) хоёр өөр е эгшгийг тэмдэглэсэн гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

Төмөртоого, 2023: *Төмөртоого Д. Дөрвөлжин бичгийн үсэг зүйд үзүүлсэн уйгуржин монгол бичгийн нөлөө // Хоёрдугаар удаагийн бүх улсын умард хязгаарын үндэстнүүдийн үсэг зүй ба толь зүйн эрдэм шинжилгээний судлан ярилцах хурлын өгүүлийн товхимол. Хөх хот, 2023. Х. 32–35.*

Tumurtogo D. Durwuldzhin bichgiin useg dsuid udsuulsen uigurdzhin mongol bichgiin nulu [The second edition of the conference paper on orthography and vocabulary of all northern border Nations] // Khoiordugar udaagiin bukh ulsiin umard khiadsgaaryn undestnuudiin useg ba dsuin erdem shindzhilgeenii sudlan yariltzakh khurkyn uguuliin tovkhimol. Khukh khot, 2023. Kh. 32–35.

Зууннаст, 1990: 照那斯图, 有关八思巴字母è的几个问题 // 八思巴字和蒙古语文献 I 研究文集 [Nastu Several questions about the development of the Eight Siba alphabet // Collection of Research on the Eight Siba characters and Mongolian Literature]. Institute for the study of language & Cultures of Asia & Africa, Tokyo University of foreign studies, 1990. P. 23–29.

Мөнхсайхан, 2021: *Мөнхсайхан С. Монголын нууц товчооны бичвэр судлал. Уб, 2021. Х. 102–103.*

Munkhsaikhan C. Mongolyn nuts товчооны buchveer sudlal [Studying the text of the Mongolian “Secret Legend”]. Ulaanbaatar, 2021. P. 102–103.

FEATURES OF THE PHONEMES OF VOWELS “A” AND “E” OF MEDIEVAL MONGOLIAN

Serjee MUNKHSAIKHAN

The Institute of Language and Literature MAS

The written records that have been passed down to us are valuable sources for investigating the history of the Mongolian language. In particular, Mongolian records, written in Chinese letters are highly suitable for studying various linguistic aspects such as phonology, morphology, and lexicology of medieval Mongolian because they reveal the active spoken language of their time. In this article, based on the facts, the author discussed the features of the vowels “a” and “e” in the Uyghur-Mongol script and *phags-pa* script based on their phonological articulation. As a result of the research, the author concluded that there were two distinct forms of the vowel “e”, which have differing pronunciations because there are numerous examples of Mongolian records written in Chinese letters that differentiated between them.

Key words: Uyghur-Mongol script, *phags-pa* script, Mongolian records-written in Chinese letters, vowel “a”, vowels “e”.

MUNKHSAIKHAN Serjee, Ph.D. (Philology), Associate professor, Researcher. The Institute of Language and Literature MAS (Ulaanbaatar, Mongolia)

ОСОБЕННОСТИ ФОНЕМ ГЛАСНЫХ “А” И “Э” СРЕДНЕВЕКОВОГО МОНГОЛЬСКОГО ЯЗЫКА

С. МУНХСАЙХАН

Институт языка и литературы Монгольской академии наук

Письменные памятники, дошедшие до нас являются ценными источниками для изучения истории монгольского языка. В частности, монгольские письменные памятники, написанные китайскими иероглифами, очень подходят для изучения различных лингвистических аспектов, таких как фонология, морфология и лексикология средневекового монгольского языка, поскольку они раскрывают активный разговорный язык своего времени. В данной статье, основываясь на фактах, автор рассмотрел орфографические особенности гласных “а” и “э” в уйгуро-монгольском письме и письме, так называемый “пхаг-па”, на основе их фонологической артикуляции. В результате исследования, автор пришел к выводу, что существуют две различные формы гласной “э”, которые имеют разное произношение, поскольку существуют многочисленные примеры монгольские письменные памятники, написанных китайскими иероглифами, которые различают их.

Ключевые слова: уйгуро-монгольская письменность, квадратная письменность, монгольские письменные памятники на китайском иероглифе, гласный “а”, гласный “э”.

Об авторе: **МУНХСАЙХАН Сэржээ**, Ph.D. (Philology), доцент, ведущий научный сотрудник. Институт языка и литературы АНМ (Улан-Батор, Монголия) (munkhsaikhans@mas.ac.mn).